



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/П

Улаанбаатар хот

Эзэмшиж буй газрын талбайн хэлбэр,
солбилцол өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбилцол өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 1 (нэг) иргэний талбайн хэлбэр, солбилцолыг өөрчилсүгэй.

2. Эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбилцол өөрчлөгдөж байгаа иргэнтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/263 дугаар захирамжийн Б.Бат-Эрдэнэд хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД